

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК -ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/03/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn	Санхүү-Нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер:	Х.Түвшинбаяр
	Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn	
Улаанбаатар хот 2024он	Аудитын менежер:	С.Гантөгс
	Утас: 325093 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn	
	Ахлах аудитор:	Н.Энхмэнд
	Утас: 325093 Цахим хаяг: enkhmendn@audit.gov.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 493
танай _____-ны № _____-т

БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨХК-НИЙ ЗАХИРАЛ
Н.МӨНГӨНХӨЛӨГТ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газар нь захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэхдээ барилгын стандарт, нормын дагуу сүүлийн үеийн тоног төхөөрөмж ашиглан техник хяналтын чанарыг өндөр түвшинд хийж барилга байгууламж, тохижилтын ажлыг байнгын ашиглалтад хүлээлгэн өгч байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус газрын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний өртгийг төлөвлөснөөс илүү зарцуулсан, хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан барьцааны хугацаа дууссан барьцааг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд буцаан олгоогүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,550,368,610.29	3,771,544,164.65
1.1.2	Дансны авлага	2,864,124,285.51	3,068,609,458.11
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	20,056.67	480,135,839.98
1.1.4	Бусад авлага	23,448,242.46	9,593,308.40
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,816,806,624.06	2,279,352,299.89
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	490,026,559.38	51,347,576.75
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	25,038,000.00	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	6,769,832,378.37	9,660,582,647.78
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	165,970,456,877.63	171,249,189,600.37
1.2.2	Биет бус хөрөнгө	1,978,299,543.95	3,959,900,537.93
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	468,636,524.98	421,674,406.02
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	168,417,392,946.56	175,630,764,544.32
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	175,187,225,324.93	185,291,347,192.10
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	117,118,196.58	3,098,882,321.11
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	460,580,967.88	1,065,000.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг	181,656,699.04	180,953,714.56
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	276,603,009.03	424,959,380.84
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	15,000.00	432,000.00
2.1.12	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12	Урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг	1,073,706.06	5,458,177,706.06
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,037,047,578.59	9,164,470,122.57
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	29,419,763,638.21	33,441,823,474.46
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	5,611,864,848.43	5,716,315,368.51
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		

2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	35,031,628,486.64	39,158,138,842.97
2.2	Өр төлбөрийн нийт дүн	36,068,676,065.23	48,322,608,965.54
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	62,531,339,800.00	62,531,339,800.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	73,782,460,063.53	72,311,022,635.90
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	4,070,812,537.66	4,784,384,211.03
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,266,063,141.49)	(2,658,008,420.37)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	139,118,549,259.70	136,968,738,226.56
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	175,187,225,324.93	185,291,347,192.10

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	111,644,996,008.40	163,218,494,494.88
2	Борлуулалтын өртөг	108,984,954,916.25	160,880,605,565.18
3	Нийт ашиг (алдагдал)	2,660,041,092.15	2,337,888,929.70
4	Түрээсийн орлого	12,884,989.16	31,070,550.91
5	Хүүний орлого		23,114,473.79
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,233,551,931.24	1,307,713,166.44
9	Борлуулалт, маркетингийн зардал	3,795,954,367.74	4,329,180,141.35
10	Ерөнхий ба удирдлагын зардал	659,685,995.71	500,190,448.65
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	723,656,873.46	1,342,692,671.85
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(4,434,713,292.01)	465,050,337.70
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(115,509,096.33)	(979,308,569.98)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(5,823,041,612.70)	(2,986,534,373.29)
19	Орлогын татварын зардал	(151,382,458.44)	214,344,147.52
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(5,671,659,154.26)	(3,200,878,520.81)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(5,671,659,154.26)	(3,200,878,520.81)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	62,531,339,800.00	79,374,890,274.17	4,065,812,537.66	3,934,708,892.50	149,906,751,504.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(27,919,638.58)		(5,093,623,451.79)	(5,121,543,090.37)
3	Залруулсан үлдэгдэл	62,531,339,800.00	79,346,970,635.59	4,065,812,537.66	(1,158,914,559.29)	144,785,208,413.96
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(5,671,659,154.26)	(5,671,659,154.26)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт			5,000,000.00		5,000,000.00
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(5,564,510,572.06)		5,564,510,572.06	-
9	2022 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	62,531,339,800.00	73,782,460,063.53	4,070,812,537.66	(1,266,063,141.49)	139,118,549,259.70
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				10,991,642.74	10,991,642.74
11	Залруулсан үлдэгдэл	62,531,339,800.00	73,782,460,063.53	4,070,812,537.66	(1,255,071,498.75)	139,129,540,902.44
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(3,200,878,520.81)	(3,200,878,520.81)
13	Бусад дэлгэрэнгүй орлого			713,571,673.37		713,571,673.37
14	Өмчид гарсан өөрчлөлт		326,504,171.56			326,504,171.56
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(1,797,941,599.19)		1,797,941,599.19	-
17	2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	62,531,339,800.00	72,311,022,635.90	4,784,384,211.03	(2,658,008,420.37)	136,968,738,226.56

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	90,920,554,158.94	138,017,633,773.56
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	89,371,676,841.42	136,372,355,957.74
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	81,462,870.25	60,611,882.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	1,467,414,447.27	1,584,665,933.82
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	86,155,329,902.85	131,123,021,568.52
	Ажиллагчдад төлсөн	11,141,910,316.44	14,908,044,596.85
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,364,151,454.68	4,271,371,156.80
	Бараа материал худалдан авахад төлсөн	65,133,620,915.46	102,325,275,484.89
	Ашиглалтын зардалд төлсөн	559,100,697.25	673,898,177.24
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,058,483,534.20	763,598,229.97
	Хүүний төлбөрт төлсөн	596,229,288.69	917,465,508.95
	Татварын байгууллагад төлсөн	2,538,337,003.59	4,686,649,931.91
	Даатгалын төлбөрт төлсөн	44,242,953.97	7,842,842.00
	Бусад мөнгөн зарлага	1,719,253,738.57	2,568,875,639.91
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,765,224,256.09	6,894,612,205.04
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,219,390.89	27,617,293.79
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	23,219,390.89	4,502,820.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		23,114,473.79
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,630,267,622.57	4,699,980,238.41
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,630,267,622.57	4,699,980,238.41
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,607,048,231.68)	(4,672,362,944.62)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,269,526,373.14	2,852,984,843.21
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,269,526,373.14	2,852,984,843.21

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК -ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,270,600,079.20	2,854,058,549.27
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	5,270,600,079.20	2,854,058,549.27
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,073,706.06)	(1,073,706.06)
	Валютын ханшийн зөрүү		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	157,102,318.35	2,221,175,554.36
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,393,266,291.94	1,550,368,610.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,550,368,610.29	3,771,544,164.65

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэм-жих нэгж	2022 он гүйцэтгэл	2023 он		Өөрчлөлт				
				төлөв	гүйц	өмнөх оноос		төлөв-нөөс		
						дүн	хувь	дүн	хувь	
1	1.1 Худалдан авсан цахилгаан	сая кВт*ц	518.6	491.4	612.4	93.8	118.1%	121.0	124.6%	
	ДҮТ ТӨХХК-иас	сая кВт*ц	517.0	490.1	610.3	93.3	118.0%	120.2	124.5%	
	Импортоор	сая кВт*ц	1.6	1.3	2.1	0.5	130.7%	0.8	157.5%	
	1.2 Түгээлтийн нийт алдагдал	хув иар	хувь	8.18%	7.53%	6.53%	-1.65%	-20.2%	-1.00%	-13.3%
		биетэр	сая кВт*ц	42.4	37.0	40.0	(2.4)	94.3%	3.0	108.1%
	ДҮТ ТӨХХК	хув иар	хувь	8.16%	7.50%	6.52%	-1.64%	-20.2%	-0.99%	-13.2%
		биетэр	сая кВт*ц	42.2	36.8	39.8	(2.4)	94.3%	3.0	108.1%
	Импорт	хув иар	хувь	13.71%	15.84%	10.27%	-3.44%	-25.1%	-5.57%	-35.1%
		биетэр	сая кВт*ц	0.22	0.21	0.21	(0.00)	-2.1%	0.00	102.1%
	1.3 Борлуулсан цахилгаан	сая кВт*ц	476.2	454.4	572.4	96.2	120.2%	118.0	126.0%	
	ДҮТ ТӨХХК	сая кВт*ц	474.8	453.3	570.5	95.7	120.2%	117.2	125.9%	
	Импорт	сая кВт*ц	1.371	1.109	1.863	0.49	135.9%	0.75	167.9%	

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК -ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Борлуулалтын дундаж үнэ	төг/кВ т*ц	188.94	236.58	237.11	48.17	125.5%	0.53	100.2%
2	Нийт орлого	сая төг	112,930.9	134,939.5	165,949.7	53,018.7	146.9%	31,010.2	123.0%
	Борлуулалтын орлого	сая төг	89,710.1	107,235.7	135,271.9	45,561.8	150.8%	28,036.2	126.1%
	Түгээх үйлчилгээний орлого	сая төг	21,595.3	26,659.9	27,495.2	5,899.9	127.3%	835.3	103.1%
	Импортын ЦЭХ-ний орлого	сая төг	339.6	237.2	451.4	111.9	132.9%	214.3	190.3%
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	1,285.9	806.7	2,731.2	1,445.2	212.4%	1,924.5	338.5%
3	Нийт зардал	сая төг	118,754.0	137,639.4	168,936.2	50,182.2	142.3%	31,296.8	122.7%
	ХАЦЭХ-ний өртөг	сая төг	86,672.0	101,104.2	133,611.4	46,939.4	154.2%	32,507.2	132.2%
	ХАЦЭХ-ний тариф	төг/кВ т*ц	167.64	206.31	218.93	51.29	130.6%	12.62	106.1%
	Хангах, түгээх үйл ажиллагааны зардал	сая төг	26,379.5	32,792.0	31,573.6	5,194.1	119.7%	(1,218.4)	-3.7%
	Импортын эрчим хүчний зардал	сая төг	389.1	446.7	524.9	135.9	134.9%	78.3	117.5%
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	5,313.4	3,296.6	3,226.2	(2,087.1)	-39.3%	(70.3)	-2.1%
4	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	сая төг	(5,823.0)	(2,699.9)	(2,986.5)	(2,836.5)	-48.7%	286.6	110.6%
	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	сая төг	(1,746.1)	(0.6)	(2,418.0)	671.9	138.5%	2,417.3	0.0%
	Импортын эрчим хүчний ашиг (алдагдал)	сая төг	(49.5)	(209.5)	(73.5)	24.0	148.5%	(136.0)	-64.9%
	Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	сая төг	(4,027.4)	(2,489.8)	(495.1)	(3,532.4)	12.3%	(1,994.8)	-80.1%
	Орлогын албан татвар	сая төг	(151.4)	-	214.3	365.7	141.6%	214.3	0.0%
5	Татварын дараах ашиг (алдагдал)	сая төг	(5,671.7)	(2,699.9)	(3,200.9)	(2,470.8)	-43.6%	500.9	118.6%
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.05	1.02	1.02	(0.03)	-3.2%	(0.00)	-0.20%
7	Нийт авлага	сая төг	2,887.6	3,132.7	3,609.7	722.1	125.0%	477.0	115.2%
	Үүнээс: Хэрэглэгчээс авах ЦЭХ-ний авлага	сая төг	2,681.1	2,600.0	2,967.9	286.8	110.7%	367.9	114.1%
8	Нийт өр төлбөр	сая төг	36,068.7	45,520.2	48,322.6	12,253.9	134.0%	2,802.4	106.2%
	Урт хугацаат өр төлбөр	сая төг	35,031.6	41,970.2	39,158.1	4,126.5	111.8%	(2,812.1)	-6.7%

	Богино хугацаат өр төлбөр	сая төг	1,037.0	3,550.0	9,164.5	8,127.4	883.7%	5,614.5	258.2%
	Үүнээс: НХА-ийн өглөг	сая төг		3,000.0	2,947.7	2,947.7	0.0%	(52.3)	98.3%
9	Нийт ажиллагсдын тоо	хүн	548	553	529	(18)	-3.3%	(24)	-4.3%
10	Нийт цалингийн сан	сая төг	12,125.3	15,572.9	15,439.6	3,314.3	127.3%	(133.3)	-0.9%
11	Нэг ажилтны дундаж цалин /сарын/	төгрөг	1,845,553	2,345,312	2,430,665	585,112	131.7%	85,353.1	103.6%
12	Цахилгаан тасалдлын дундаж хугацаа И сайди	мину т	734.7	722.0	721.1	(13.6)	-1.9%	(0.9)	-0.1%
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая төг	4,742.3	5,260.1	4,317.9	(424.4)	91.1%	(942.2)	82.1%
	Үүнээс: Хөрөнгө оруулалт	сая төг	1,985.9	1,201.2	980.3	(1,005.6)	49.4%	(220.9)	81.6%
	Их засвар	сая төг	760.5	693.2	510.8	(249.7)	67.2%	(182.4)	73.7%
	ТЗБАХ	сая төг	1,995.9	3,365.7	2,826.8	830.9	141.6%	(538.9)	84.0%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,168,119.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1,743.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 212,727.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 953,648.3 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

¹Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл
/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
Тус байгууллага тайлант хугацаанд шатахууны зардлыг зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв бөглөөгүй, спидометрийн заалт зөрүүтэй зэрэг анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй зарцуулсан байна.	1	425,757.8					1	425,757.8				
Бараа материалын тайланд зарлагын баримтыг хэвлэж хавсаргадаггүй, шаардах хуудсаар зарлагдаж байна.	1	127,558.8					1	127,558.8				
Ковид-19 цар тахлын гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах хэрэгсэл худалдан авсан.	1	27,000.8					1	27,000.8				
Урсгал засварын зардлыг төлөвлөхдөө эрчим хүчний бүх үйлдвэр, аж ахуйн газруудын нийтээр дагаж мөрдөх тоног техник ашиглалтын дүрмийг үндэслэсэн байна.	1	373,330.9					1	373,330.9				
Зайлшгүй танхимаар сурах сургалтаас /Өргөх машин механизмын, ХАБ/ бусад сургалтыг зохион байгуулсан байна.	1	20,350.6			1	20,350.6						
Байгууллагын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2021-2022 онд байгуулсан хамтын гэрээг үндэслэн ажиллагсдад буцалтгүй тусламж олгосон байна.	1	192,377.2			1	192,377.2						

Томилолтоор ажиллаж байгаа ажилчдад хоолны тооцоо давхардуулж гаргасан	1	1,743.0	1	1,743.0								
Дүн	7	1,168,119.1	1	1,743.0	2	212,727.8	4	953,648.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд шатахуун нийлүүлэх худалдан авах ажиллагаа зохион байгуулсан. Салбар компаниуд ХАА-ны дагуу байгуулсан гэрээний хавсралтад заасан үнийн дүнгээр бус зах зээл дээрх үнээр худалдан авалтыг хийсэн байна.	1	367,669.3			1	367,669.3		
Дүн	1	367,669.3			1	367,669.3		
Нийт дүн	8	1,535,788.4	1	1,743.0	1	580,379.1	4	953,648.3